



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/249

Хэрлэн сум


Арга хэмжээнд оролцуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зүүн хойд Азийн нутгийн захиргааны холбооны Хэрэг эрхлэх газраас 2024 оны 05 дугаар сарын 22-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрүүдэд гишүүн орон нутгуудын гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хуралд Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтэн Даваанямын Ууганбаярыг оролцуулж 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ